

## 1995 оны мал тооллого

### I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

**I.1. Малчдын тоо, бүрэлдэхүүн.** 1995 оны жилийн эцсийн мал тооллогоор мал аж ахуйн салбарт нийт 169.3 мянган өрх бүхий 390.5 мянган малчид ажиллаж байна. Малчдын тоо өмнөх оныхоос 3.6 хувь буюу 13.4 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 57.7 хувь нь 16-35 насны залуучууд, 24.4 хувь нь тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна.

#### Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1991	1992	1993	1994	1995	1995\1994 хувь
Малчин өрх (мян)	114.0	143.4	153.6	167.3	169.3	101.2
Малчдын тоо (мян)	247.5	330.1	347.9	377.1	390.5	103.6
Үүнээс: 16-35 насны	139.8	174.6	186.8	204.8	225.2	110.0
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	77.1	97.2	96.1	106.3	95.4	89.7
Тэтгэврийн насны	30.6	58.3	65.0	66.0	69.9	105.9
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Үүнээс: 16-35 насны	56.5	52.9	53.7	54.3	57.7	
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	31.1	29.4	27.6	28.2	24.4	
Тэтгэврийн насны	12.4	17.7	18.7	17.5	17.9	

1994 онд нэг малчин өрхөд дунджаар 71 толгой мал ногдож байсан бол 1995 онд 73 толгой болов. Орхон, Архангай, Хөвсгөл аймгийн нэг малчинд 39-49 толгой мал ногдож байхад Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймагт 101-257 толгой мал ногдож байна. (Хавсралт хүснэгтийн 1-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хуудасны дугаарыг заана)

**1.2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт.** 1995 онд нийт малчин өрхийн 11.3 хувь буюу 19.1 мянган өрх цахилгааны эх үүсвэрээр хангагдсаны дотор 2.3 мянган өрх салхины үүсвэртэй байна. Улаанбаатар хот, Дархан-Уул аймгийн малчин өрхийн 54.9-55.4 хувь, Сэлэнгэ; Орхон аймгийнх 35.4-38.2, Дорнод, Хэнтий аймгийн малчин өрхийн 21.6-28.4 хувь нь цахилгаан гэрэлтэй болжээ. ( Хавсралт хуудасны дугаар 2-3 )

Харин Өвөрхангай, Баян-Өлгий, Архангай, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгийн малчин өрхийн 4.0-8.3 хувь нь цахилгаан эх үүсвэртэй байгаа нь аймгууд дотроос хамгийн доогуур түвшинд байна. Салхин хөдөлгүүртэй цахилгаан эх үүсвэрээр Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, аймгийн малчид харьцангуй илүүтэй хангагджээ.

1994 онд малчин өрхийн 6.5 хувь буюу 10.9 мянган өрх телевизортэй, байсан бол 1995 онд 9.9 хувь буюу 16.8 мянга, Нийслэл хот, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгийн малчин өрхийн 30.4-37.3 хувь, Дорнод, Хэнтий, Дундговь, Төв, Булган, Дорноговь, Ховд, Баянхонгор аймгийнх 10.8-23.8 хувь телевизортой болсон нь бусад аймгуудаас дээгүүр үзүүлэлттэй байна.

1995 оны мал тооллогоор нийт малчин өрхийн гуравны хоёр нь радио хүлээн авагчтай, дөрөвний гурав нь оёдлын машинтай, 15.8 хувь нь мотоциклтэй, 2.9 хувь авто машинтай, 3.2 хувь шинэ гэр барьсан, 19.5 хувь нь эсгий хийсэн 0.2 хувь богино долгионы холбоотой болсон судалгаа гарч байна. Говийн гурван аймаг болон Говь-Алтай, Баянхонгор аймгийн малчин өрхийн 20.9-29.9 хувь мотоциклтэй болжээ. Харин радио хүлээн авагчтай малчин өрхийн тоо 1994 оныхоос буурчээ.

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт (мян.өрх)

	1991	1992	1993	1994	1995	1995\1994 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх %	
							1994	1995
Цахилгаан гэрэлтэй	12.3	15.5	16.5	19.7	19.1	97.0	11.8	11.3
Үүнээс: салхины хөдөлгүүртэй					1.6			0.9
Телевизортэй	4.2	6.9	10.6	10.9	16.8	154.1	6.5	9.9
Богино долгион холбоотой өрх	20	30	145	308	316	102.6	0.2	0.2
Радио хүлээн авагчтай	92.7	103.8	105.2	114.1	111.3	97.5	68.2	65.7
Авто машинтай					4.9			2.9
Мотоциклтэй					26.7			15.8
Оёдлын машинтай					125.6			74.2
Шинэ гэр барьсан					5.3			3.2
Эсгий хийсэн	12.1	25.4	26.2	29.8	33.0	110.7	17.8	19.5

**1.3. Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ хангамж.** 1995 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд малын эмч 1634, мал зүйч 308 ажиллаж байгаа нь өмнөх оныхоос

мал зүйчийн тоо 8.3 хувь, малын эмчийн тоо 4.7 хувиар буурсан байна. Одоо улсын хэмжээгээр нэг мал зүйчид дунджаар 92.8 мян.мал, нэг малын эмчид 17.5 мян.мал ногдож байгаа нь өмнөх оныхоос нэмэгджээ.

Сэлэнгэ аймагт нэг мал зүйчид 16.8 мян.мал ногдож байхад Өмнөговь, Говь-Алтай аймагт нэг мал зүйчид 300-аас дээш мян.толгой мал ногдох боллоо. ( Хавсралт хуудасны дугаар 4 )

Мал аж ахуйн мэргэжилтний тоо, хангамж (мян)

	1989	1992	1993	1994	1995	1995\1994%
Мал зүйч	787	501	485	379	308	81.3
Малын эмч	1599	1661	1668	1715	1634	95.3
Нэг мал зүйчид ногдох малын тоо ( мян.тол )	32.4	51.3	51.9	70.7	92.8	131.3
Нэг малын эмчид ногдох малын тоо ( мян.тол )	16.0	15.5	15.1	15.6	17.5	112.2

## II. МАЛЫН ТОО

**2.1. Нийт малын тоо.** 1995 оны эцэст 28.6 сая мал тоологдсон нь 1994 оныхоос 6.6 хувь буюу 1764.2 мянган толгойгоор өссөний дотор ямаа 1279.4 мянга, үхэр 311.9, адуу 239.5, тэмээ 1.4 мянгаар нэмэгдэж, харин хонь 68.0 мянгаар хорогдлоо. Бодод шилжүүлснээр малын тоо 1994 оныхоос 702.1 мянгаар өссөн байна.

Малын тоо ( мян.тол)

	1991	1992	1993	1994	1995	1995/1994	
						%	Зөрүү
<b>Бодоор *</b>	<b>8905.0</b>	<b>8785.3</b>	<b>8532.2</b>	<b>9166.2</b>	<b>9862.8</b>	<b>107.7</b>	<b>702.1</b>
<b>Толгойн тоо</b>	<b>25527.9</b>	<b>25694.1</b>	<b>25174.7</b>	<b>26808.1</b>	<b>28572.3</b>	<b>106.6</b>	<b>1764.2</b>
Тэмээ	476.0	415.2	367.7	366.1	367.5	100.4	1.4
Адуу	2259.3	2200.2	2190.3	2408.9	2648.4	109.9	239.5
Үхэр	2822.0	2819.2	2730.5	3005.2	3317.1	110.4	311.9
Хонь	14721.0	14657.0	13779.2	13786.6	13718.6	99.5	-68.0
Ямаа	5249.6	5602.5	6107.0	7241.3	8520.7	117.7	1279.4

\* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

17 аймаг, Улаанбаатар хот урьд онд байсан малаа толгойн дүнгээр өсгөсний дотор Баян-Өлгий, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд,

Завхан, Орхон аймаг 6.9-17.1 хувь буюу 16.4-248.8 мянгаар, таван төрөл дээр нь өсгөв. Бодод шилжүүлсэнээр Сүхбаатар, Дорнодоос бусад аймгийн мал 1.8-19.9 хувиар өсчээ. Сумдаас Төв аймгийн Алтанбулаг, Баян-Өлгийн Алтанцөгц, Өвөрхангайн Нарийнтээл, Дундговийн Дэлгэрцогт, Өмнөговийн Гурвантэс зэрэг 16 аймгийн 114 сум малаа таван төрөл дээр нь өсгөжээ.

Толгойн тоогоор үзвэл Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дархан-Уул аймгийн мал 0.3-9.1 хувь буюу 0.9-71.3 мянган толгойгоор хорогдсон байна.

Хонин сүргийн тоо 12 аймаг, хотод буурсны дотор Сүхбаатар аймагт 90.0 мянга, Архангай, Дорнод, Хэнтий, Увс, Хөвсгөл аймагт 33.8-58.0 мянгаар цөөрчээ. (Хавсралт хуудасны дугаар 9,10)

Дорнодын Чулуунхороот, Баян-Уул, Халхгол, Баяндун, Хэнтийн Уулбаян, Баян-Адрага, Архангайн Батцэнгэл, Сүхбаатарын Халзан сумдын мал урьд оныхоос 7.7-34.4 хувь буюу 5.5 – 25.4 мянгаар хорогдсон нь бусад сумдаас харьцангуй их байна.

Малын өсөлт, бууралтын хэмжээгээр аймгуудыг байр эзлүүлбэл :

	1995 \ 1994			
	Бодод шилжүүлсэнээр		Толгойн тоогоор	
	хувь	мян.бод	хувь	мян.тол
1.Баян-Өлгий	116.8	55.4	117.1	197.6
2.Дундговь	112.7	59.1	112.6	192.4
3.Баянхонгор	112.4	70.1	111.6	104.7
4.Өвөрхангай	111.9	92.3	110.6	248.8
5.Өмнөговь	110.6	37.0	115.2	159.0
6.Төв	110.3	62.7	108.4	136.5
7.Ховд	109.6	51.2	108.7	165.7
8.Завхан	109.5	66.0	106.9	154.6
9.Говь-Алтай	107.8	38.3	106.5	129.1
10.Булган	107.8	35.7	105.4	58.2
11.Дорноговь	106.6	20.1	107.5	62.0
12.Хөвсгөл	106.6	49.4	103.9	69.4
13.Увс	104.4	23.4	102.7	46.3
14.Архангай	103.8	26.8	100.0	0.1
15.Сэлэнгэ	103.6	6.9	101.7	8.3
16.Хэнтий	101.8	8.3	99.7	-3.1
17.Сүхбаатар	98.3	-7.5	93.4	-71.3
18.Дорнод	93.9	-17.8	90.9	-58.9
19.Орхон	119.9	8.3	114.8	16.4
20.Улаанбаатар	108.9	10.1	106.1	16.9
21.Говьсүмбэр	107.2	2.2	105.4	5.3
22.Дархан-Уул	105.5	2.9	99.4	-0.9

Манай орны түүхэнд хамгийн олон мал, тэрчлэн адуу, үхэр, ямаа 1995 онд тоологдов.

Малын, тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	28572.3	1995	28572.3	1995
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	2648.4	1995	2648.4	1995
Үхэр	3317.1	1995	3317.1	1995
Хонь	15936.4	1941	15083.0	1990
Ямаа	8520.7	1995	8520.7	1995

Урьд оныхтой харьцуулбал тэмээний зах зээл, хүнсний хэрэглээний зарлага 3.0 мянгаар илүү хэдий ч 100 эхээс бойжуулах ботго нэмэгдэж зүй бус хорогдол 0.2 мянгаар багасч тэмээн сүргийн тоо сүүлийн жилүүдэд анх удаа өмнөх оныхоос 1.4 мянгаар өслөө.

1990 оноос хойш сүүлийн таван жилд сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин мэдэгдэхүйц буурч ирлээ.

#### Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1991	1992	1993	1994	1995
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Тэмээ	2.1	1.9	1.6	1.5	1.4	1.3
Адуу	8.8	8.8	8.6	8.7	9.0	9.3
Үхэр	11.0	11.0	11.0	10.8	11.2	11.6
Хонь	58.3	57.7	57.0	54.7	51.4	48.0
Ямаа	19.8	20.6	21.8	24.3	27.0	29.8

Улсад нийт малын тоогоор болон адуугаар Өвөрхангай, хониор Завхан, үхрээр Хөвсгөл, ямаагаар Баянхонгор, тэмээгээр Өмнөговь аймаг тэргүүн байранд хэвээр байна.

1994 оны байдлаар манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 8 дугаар, тэмээгээр 9, ямаагаар 17, хониор 22, үхрээр 57 дугаар байрт орж байна.

#### Адуу, тэмээний тоо 1994 оны байдлаар ( мян.тол )

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний Тоо
1.Хятад	9960	1.Сомали	6000
2.Мехсик	6191	2.Судан	2856
3.Бразил	5800	3.Энэтхэг	1520
4.АНУ	3860	4.Пакистан	1121
5.Аргентин	3369	5.Мавритан	1000
6.Этиоп	2750	6.Этиоп	1000
7.ОХУ	2500	7.Кени	815
8.Монгол	2409	8.Чад	593
		9.Саудын араб	415
		10.Хятад	373
		11.Монгол	366

1994 оны байдлаар манай улс нэг хүн амд ногдох адуугаар дэлхийд 1, ямаагаар 2, тэмээгээр 3, хониор 4 дүгээр байранд орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл : ( толгой )

Адуугаар	Тэмээгээр	Хониор	Ямаагаар
1.Монгол 1.0	Сомали 0.7	Шинэ зеланд 14.2	Мавритан 3.3
2.Аргентин 0.1	Мавритан 0.5	Австрали 7.4	Монгол 3.2
3.Казахстан 0.08	Монгол 0.2	Уругвай 7.4	Сомали 1.3
4.Мексик 0.07	Судан 0.1	Монгол 6.0	Мали 0.7
5.Кыргызстан 0.06	Чад 0.1	Казахстан 2.0	Судан 0.6
		Туркменистан 1.5	

**Хувийн ( амины ) малын тоо.** 1995 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 283.9 мянган өрх тоологдсоны дотор 59.6 хувь буюу 169.3 мянга нь малчин өрх , 40.4 хувь буюу 120.6 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна.

Нийгмийн малыг хувьчилснаар хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1995 онд 92.6 хувийг эзлэх болов. 1995 онд хувийн малын тоо 26.4 саяд хүрч, 1994 оныхоос 1919.9 мянгаар нэмэгдэв. Ямаа, адуу, үхрийн 94.7 – 96.6 , хонины 88.9 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Дорнод, Сүхбаатараас бусад бүх аймаг, хотод хувийн малын тоо урьд оныхоос 0.8 – 22.5 хувиар өссөний дотор Өвөрхангай, Баянхонгор аймагт 231.0 – 240.2 мянга, Баян-Өлгий, Дундговь, Ховд аймагт 172.9 – 197.8 мянга, Өмнөговь, Завхан, Төв, Говь-Алтай аймагт 132.8 – 158.6 мянгаар нэмэгдэв.

Хувийн малын өсөлт ( мян.тол )

	Толгойн тоо			1995\1994	
	1993	1994	1995	хувь	зөрүү
Архангай	1436.6	1570.2	1577.9	100.5	7.7
Баян-Өлгий	975.5	1126.8	1324.6	117.6	197.8
Баянхонгор	1623.6	1903.8	2134.8	112.1	231.0
Булган	901.3	953.5	1018.6	106.8	65.1
Говь-Алтай	1687.0	1911.5	2044.3	106.9	132.8
Дорноговь	660.1	711.3	776.5	109.2	65.2
Дорнод	533.8	503.3	466.9	92.8	-36.5
Дундговь	1429.2	1470.5	1660.8	112.9	190.3
Завхан	1920.8	2176.2	2330.4	107.1	154.2
Өвөрхангай	1997.6	2225.1	2465.3	110.8	240.2
Өмнөговь	857.8	1001.0	1159.6	115.8	158.6
Сүхбаатар	884.1	895.0	894.8	100.0	-0.2
Сэлэнгэ	255.4	298.5	314.0	105.2	15.5
Төв	1231.4	1278.7	1420.8	111.1	142.1
Увс	1509.7	1601.8	1657.0	103.4	55.2
Ховд	1665.6	1771.6	1944.5	109.8	172.9
Хөвсгөл	1576.6	1715.4	1789.1	104.3	73.7

Хэнтий	1009.4	952.5	959.7	100.8	7.3
Дархан-Уул	87.8	101.0	102.4	101.4	1.4
Улаанбаатар	206.9	229.5	250.2	109.0	20.6
Орхон	71.5	81.3	95.4	117.3	14.0
Говьсүмбэр	43.5	48.7	59.6	122.5	11.0
ДҮН	22565.2	24527.2	26447.2	107.8	1919.9

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 46.1 хувь, ямаа 31.1, үхэр 11.9, адуу 9.6, тэмээ 1.3 хувийг эзлэж байна.

Хувийн мал аж ахуйн мал, төрлөөр ( мян.тол )

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү ү н э э с				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1990	262.3	<b>8242.9</b>	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	<b>14002.6</b>	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	<b>18081.1</b>	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	<b>22565.2</b>	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	<b>24527.2</b>	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	<b>26447.2</b>	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0

Иргэдийн амины малын бүлэглэлтээс үзвэл 51-100 малтангууд бусад бүлгээс харьцангуй олонхи нь байна.

1995 онд 100 хүртэл малтай өрхүүдийн хувийн жин өмнөх оныхоос буурч, 100-аас дээш малтай өрхийн хувийн жин нэмэгдсэн байна.

Цөөн малтай ( 1-10, 11-30, 31-50, 51-100 малтан ) өрхийн тоо, хувийн жин өмнөх оныхоос 1991 оноос эхлэн жил дараалан буурах хандлагатай байхад 100-аас дээш малтай бүлгүүдийн өрхийн тоо нэмэгдэж ирсэн байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт ( тоо-мян )

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо ( мян.тол )	
	1994	1995	1994	1995	1994	1995
10 хүртэл малтай	46772	43994	16.2	15.4	295.6	273.4
11-30 малтай	53766	50580	18.6	17.8	1098.4	1048.0
31-50 малтай	42007	40200	14.5	14.2	1711.8	1617.2
51-100 малтай	62947	61082	21.8	21.5	4613.9	4569.5
101-200 малтай	53160	53564	18.4	18.9	7480.3	7642.7
201-500 малтай	28249	23139	9.8	11.0	7865.5	9036.1
501-1000 малтай	2123	3095	0.7	1.1	1297.3	1905.6
1001-1500 малтай	137	280		0.1	151.0	309.8
1501-2000 малтай	4	17			6.3	27.8
2001-с дээш мал	3	8			6.5	16.9

Улсын дунджаар малтай нэг өрхөд 33 бод, 93 толгой мал ногдож байхад Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай аймагт 41-52 бод, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь, Ховд, Баянхонгор, Дорноговь, Завхан аймагт 122-169 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

	Бодод шилжүүлснээр			Толгойн тоогоор		
	1993	1994	1995	1993	1994	1995
Архангай	28.3	30.7	32.1	66	71	72
Баян-Өлгий	21.0	22.9	26.1	74	80	92
Баянхонгор	28.3	32.5	36.9	98	115	129
Булган	30.7	32.8	39.5	73	75	89
Говь-Алтай	33.2	38.5	41.1	131	154	162
Дорноговь	36.6	43.3	45.1	99	117	122
Дорнод	22.9	24.2	24.4	51	51	50
Дундговь	42.7	44.8	51.8	141	146	169
Завхан	31.4	35.8	39.2	102	114	122
Өвөрхангай	27.7	31.2	35.4	84	94	105
Өмнөговь	38.2	41.9	45.7	108	124	141
Сүхбаатар	34.1	34.9	37.2	87	85	88
Сэлэнгэ	9.2	10.3	11.8	21	24	27
Төв	23.3	25.8	30.0	60	65	74
Увс	25.1	26.6	28.6	80	84	88
Ховд	32.7	34.6	38.3	115	119	131
Хөвсгөл	27.8	30.4	33.3	68	73	78
Хэнтий	31.4	31.9	34.5	78	74	78
Дархан-Уул	6.9	8.4	9.3	17	20	21
Улаанбаатар	6.9	8.2	9.9	17	20	23
Орхон	8.1	10.4	12.6	19	26	30
Говьсүмбэр	13.7	16.4	19.9	36	41	52
ДҮН	26.7	29.4	32.6	78	85	93

**Хээлтэгч мал.** 1995 оны эцэст 11542.2 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 28.9 мянгаар өссөний дотор эм ямаа 336.2 мянга, гүү 56.8 мянга, үнээ 7.2 мянга, ингэ 0.5 мянгаар өсч, эм хонь 371.8 мянгаар буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1991	1992	1993	1994	1995	1995\1994	
						Хувь	Зөрүү
Ингэ	127.3	112.2	99.2	100.8	101.3	100.5	0.5
Гүү	575.6	566.0	580.2	650.3	707.1	108.7	56.8
Үнээ	1064.0	1032.2	1043.0	1170.6	1177.8	100.6	7.2
Эм хонь	7407.2	7098.8	6476.9	6320.1	5948.3	94.1	-371.8
Эм ямаа	2466.3	2653.9	2880.4	3271.5	3607.7	110.3	336.2
<b>ДҮН</b>	<b>11640.4</b>	<b>11463.1</b>	<b>11079.7</b>	<b>11513.3</b>	<b>11542.2</b>	<b>100.3</b>	<b>28.9</b>



12 аймаг, хот хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос бууруулсны дотор Архангай, Сүхбаатар аймаг 57.7 – 63.5 мянга, Дорнод, Хэнтий аймаг 21.0-29.2 мянга, Булган, Төв, Увс, Хөвсгөл аймаг 12.5 – 19.0 мянгаар хорогдуулжээ. ( Хавсралт хуудасны дугаар 19 – 21 )

Бүх хээлтэгч малын 91.1 хувь нь хувийн, 8.9 хувь нь аж ахуйн бусад хэвшилд хамрагдаж байгаагийн дотор ингэний 94.3, гүүний 95.5, үнээний 93.9, эм хонины 86.9, эм ямааны 96.2 хувь хувийн аж ахуйд байна.

1995 онд хамгийн олон үнээ, гүү, эм ямаа тоологдлоо.

1961 оноос хойш олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	Он		мян.тол	Он
Ингэ	226.9	1961	Эм хонь	7786.1	1990
Гүү	708.0	1995	Эм ямаа	3600.9	1995
Үнээ	1176.3	1995			

**Төл бойжилт.** 1995 онд гарсан төлийн 93.0 хувь буюу 9.0 сая төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 382.4 мянгаар нэмэгджээ . Бойжуулсан нийт төлөөс 53.3 мянгыг аж ахуйн дотоод хэрэгцээнд, 7.0 мянгыг каракуль арьсанд нядалжээ. ( Хавсралт хуудасны дугаар 22 )

Төл бойжилт ( мян.тол )

	Бүгд	Ү Ү Н Э Э С					Зөрүү
		ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	9685.9	43.7	473.3	948.1	5347.1	2873.7	515.7
Бойжсон	9012.4	40.5	451.2	920.4	4969.2	2631.1	382.4
Хорогдсон	673.5	3.2	22.1	27.7	377.9	242.6	133.3
Бойжилтын хувь	93.0	92.5	95.3	97.1	92.9	91.6	-1.1

Бойжуулсан төл ( мян.тол )

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994	1995
Ботго	60.3	52.9	44.7	36.6	36.7	40.5
Унага	324.2	343.8	314.9	289.8	387.6	451.2
Тугал	711.9	762.5	725.2	669.3	812.9	920.4
Хурга	6152.8	6468.8	5726.8	4906.6	5085.2	4969.2
Ишиг	1772.7	1983.7	1924.7	1860.5	2307.6	2631.1
<b>Бүгд</b>	<b>9021.9</b>	<b>9611.7</b>	<b>8736.3</b>	<b>7762.8</b>	<b>8630.0</b>	<b>9012.4</b>

1995 онд хамгийн олон унага, тугал, ишиг бойжуулан авав.

1961 оноос хойших хугацаанд хамгийн олон төл бойжуулсан жил

	мян.төл	он		мян.төл	он
<b>Бүгд</b>	<b>9673.3</b>	<b>1989</b>	Тугал	920.4	1995

Ботго	74.4	1975	Хурга	6569.6	1989
Унага	451.2	1995	Ишиг	2631.1	1995

1995 онд 100 эхээс бойжуулсан төл, хамгийн өндөр байсан өмнөх таван жилийн ( 1986-1990 ) дунджаас 3-аар бага байгааг төлийн төрлөөр авч үзвэл дунджаас тугал 10, унага 7 –оор их, хурга 7-оор бага, ботго, ишиг дунджийн түвшинд бойжсон байна.

#### 100 эхээс бойжуулсан төл

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994	1995
Ботго	40	38	35	32	37	40
Унага	62	61	55	51	67	69
Тугал	69	68	68	65	78	79
Хурга	86	83	77	69	79	79
Ишиг	80	82	78	70	80	80
<b>Бүгд</b>	<b>81</b>	<b>80</b>	<b>75</b>	<b>68</b>	<b>78</b>	<b>78</b>

100 хээлтэгчээс Баян-Өлгий, Өвөрхангай, Завхан аймаг 88-95, Дундговь, Өмнөговь, Ховд аймаг 81-84 төл бойжуулсан байхад Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймаг 59-63, Сэлэнгэ, Хэнтий, Архангай аймаг 66-71 төл бойжуулжээ. ( Хавсралт хуудасны дугаар 23 )

Хувийн малын 100 эх малаас бойжуулсан төл мал аж ахуйн бусад хэвшлийнхээс 24-өөр, үүний дотор ботго 22, унага 32, тугал 36, хурга 24, ишиг 31-ээр илүү байна.

#### Хувийн аж ахуйн 100 эхээс бойжуулсан төл

	1991	1992	1993	1994	1995
Ботго	51	49	42	39	42
Унага	76	68	60	70	71
Тугал	85	86	78	82	81
Хурга	96	93	86	82	82
Ишиг	87	88	82	82	82
<b>Бүгд</b>	<b>90</b>	<b>89</b>	<b>82</b>	<b>81</b>	<b>81</b>

**Том малын зүй бус хорогдол.** 1995 оны эхний малын 2.5 хувь буюу 673.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 1994 оныхоос 16.1 мянга, 1986-1990 оны дунджаас 78.0 мянгаар багассан байна.

#### Том малын зүй бус хорогдол ( мян.тол )

	1986- 1990оны дундаж	1991	1992	1993	1994	1995
Тэмээ	25.8	20.8	21.4	23.8	9.5	7.5
Адуу	64.3	72.7	80.6	140.4	41.6	48.1

Үхэр	79.5	104.6	118.1	278.9	78.3	84.6
Хонь	438.7	624.1	516.6	927.9	423.8	403.2
Ямаа	143.6	156.0	134.3	281.1	136.8	130.5
<b>Бүгд</b>	<b>751.9</b>	<b>978.2</b>	<b>871.0</b>	<b>1652.1</b>	<b>690.0</b>	<b>673.9</b>

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1986-1990оны дундаж	1991	1992	1993	1994	1995
Тэмээ	4.7	3.9	4.5	5.7	2.6	2.0
Адуу	3.1	3.2	3.6	6.4	1.9	2.0
Үхэр	3.1	3.7	4.2	9.9	2.9	2.8
Хонь	3.3	4.1	3.5	6.3	3.1	2.9
Ямаа	3.2	3.0	2.6	5.0	2.2	1.8
<b>Бүгд</b>	<b>3.3</b>	<b>3.8</b>	<b>3.4</b>	<b>6.4</b>	<b>2.7</b>	<b>2.5</b>

Дархан-Уул, Сүхбаатар, Дорнод, Архангай, Говьсүмбэр, Сэлэнгэ, Орхон аймагт оны эхний малын 5.1-8.8 хувь буюу нийтдээ 261.5 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдлын 38.8 хувийг эзлэж байна. ( Хавсралт хуудасны дугаар 24 )

Том малын зүй бус хорогдолын 39.0 хувь буюу 262.9 мянга нь өвчнөөр, 14.5 хувь буюу 97.9 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов. Хорогдсон нийт малын 77.0 хувь нь хувийн мал байна. Хувийн малын 2.1 хувь, аж ахуйн бусад хэвшлийн малын 6.8 хувь хорогдов.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	ОН	мян.тол	ОН
<b>Бүгд</b>	<b>510.3</b>	<b>1989</b>	<b>2663.8</b>	<b>1968</b>
Тэмээ	7.5	1995	66.3	1966
Адуу	41.6	1994	235.3	1968
Үхэр	52.3	1974	278.9	1993
Хонь	293.2	1989	1606.3	1968
Ямаа	89.3	1989	574.8	1968

**Малын хээл хаялт, сувайралт.** 1995 оны эхний хээлтэгч малын 11.1 хувь буюу 1276.3 мянга нь хээл хаяж, сувайрсан нь 1994 оныхоос 6.1 хувь буюу 83.4 мянгаар цөөрсөн хэдий ч эм хонь, ямааны хээл хаялт, сувайралт 1986-1990 оны дунджаас 20.8-34.5 хувь буюу 57.3- 154.0 мянгаар нэмэгдсэн байна.

Дархан-Уул, Сэлэнгэ аймаг оны эхний хээлтэгч малынхаа 20.3-23.4, Улаанбаатар хот, Дорнод, Хөвсгөл, Орхон аймаг 17.0-18.9 хувиас дээрхи шалтгаанаар төл авч чадсангүй. ( Хавсралтын хуудасны дугаар 25- 27 )

Мал хээл хаях, сувайрах шалтгааны зонхилох нөлөөллөөр Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймаг 1995 онд 100 эхээс хамгийн цөөхөн төл бойжуулсан нь улсын дунджаас 15-19 толгойгоор бага байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо ( мян.тол )

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан			
	1986-1990 дундаж	1994	1995	1995\1986-90 хувь	1986-1990 дундаж	1994	1995	1995\1986-1990 хувь
Ингэ	12.5	11.3	9.7	77.6	9.9	9.5	7.9	79.8
Гүү	180.1	154.4	152.3	84.6	158.1	121.3	117.4	74.3
Үнээ	278.1	183.4	181.1	65.1	240.8	148.9	143.7	59.7
Эм хонь	446.3	669.8	600.3	134.5	276.0	483.4	418.5	151.6
Эм ямаа	275.6	340.8	332.9	120.8	139.7	204.6	202.2	144.7
<b>ДҮН</b>	<b>1192.6</b>	<b>1359.7</b>	<b>1276.3</b>	<b>107.0</b>	<b>824.5</b>	<b>967.7</b>	<b>889.7</b>	<b>107.9</b>

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс сувайрсан		
	1986-1990 о\д	1994	1995	1986-1990	1994	1995
Ингэ	8.2	11.4	9.7	6.5	9.5	7.9
Гүү	34.4	26.6	23.4	30.2	20.9	18.1
Үнээ	26.9	17.6	15.5	23.3	14.3	12.3
Эм хонь	6.2	10.3	9.5	3.8	7.5	6.6
Эм ямаа	12.5	11.8	10.2	6.3	7.1	6.2
<b>ДҮН</b>	<b>10.8</b>	<b>12.3</b>	<b>11.1</b>	<b>7.4</b>	<b>8.7</b>	<b>7.7</b>

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	645.8	1963	1907.9	1977
Ингэ	9.7	1995	26.4	1973
Гүү	152.3	1995	333.6	1973
Үнээ	106.1	1962	326.0	1981
Эм хонь	190.6	1962	913.0	1993
Эм ямаа	124.7	1963	558.1	1968

**Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо.** Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 57 эм хонь, 53 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироонд ноднингынхоос нааштай хандлага гарсан боловч хуц, ухна дутагдалтай хэвээр байна.

Хээлтүүлэгч малын тоо ( мян.тол )

	Бүгд				үүнээс шинээр тавьсан			
	1993	1994	1995	1995\1994	1993	1994	1995	1995\1994
Буур	4.2	4.7	4.8	102.1	60	62	95	153.2
Азрага	85.4	92.9	101.0	108.7	0.6	0.7	1.5	214.3
Бух	55.0	57.0	58.4	102.5	0.6	1.0	1.7	170.0
Хуц	100.3	100.4	104.0	103.6	0.9	2.5	3.7	148.0
Ухна	48.2	55.9	68.6	122.7	0.4	1.1	2.1	190.9
<b>ДҮН</b>	<b>293.1</b>	<b>310.9</b>	<b>336.8</b>	<b>108.3</b>	<b>2.6</b>	<b>5.4</b>	<b>9.1</b>	<b>168.5</b>

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1994	1995	Хувийн		Бусад хэвшлийн	
				1994	: 1995	1994	: 1995
Ингэ	20-25	22	21	22	21	23	26
Гүү	12-15	7	10	7	7	11	11
Үнээ	35-45	21	20	21	20	17	17
Эм хонь	25-30	63	57	68	58	44	52
Эм ямаа	25-30	59	53	60	53	38	46

Төв, Архангай, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан, Орхон, Хөвсгөл, Булган аймгуудад хуц, Говь-Алтай, Баянхонгор аймгуудад ухна бусдаас илүү дутагдалтай байна. ( Хавсралт хуудасны дугаар 28 )

**Малын хэрэглээний зарлага.** Оны эхны нийт малын 24.5 хувьтай тэнцэх 6567.3 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулжээ. Олон жилийн дунджаар ямааны 31 – 33 хувийг хүнсэнд хэргэлдэг байсан бол 1994 онд 17 хувь, 1995 онд 16.9 хувь болж буурсаар байна. ( Хавсралт хуудасны дугаар 29 )

Малын нийт хэрэглээний зарлага. ( мян.тол )

	1986-1990 оны дундаж	1991	1992	1993	1994	1995
<b>Бүгд</b>	<b>7559.8</b>	<b>8930.5</b>	<b>7683.5</b>	<b>6617.8</b>	<b>6297.6</b>	<b>6567.3</b>
Тэмээ	38.9	93.6	84.1	59.3	28.6	31.6
Адуу	201.7	273.8	293.4	159.4	127.5	163.5
Үхэр	544.3	684.6	609.9	479.1	459.9	523.9
Хонь	5311.3	6174.6	5258.6	4845.2	4645.0	4627.1
Ямаа	1463.6	1703.9	1437.5	1074.8	1036.6	1221.2

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны	1991	1992	1993	1994	1995

	дундаж					
<b>Бүгд</b>	<b>31.8</b>	<b>34.5</b>	<b>30.1</b>	<b>25.8</b>	<b>25.0</b>	<b>25.5</b>
Тэмээ	7.1	17.4	17.7	14.3	7.8	8.6
Адуу	9.5	12.1	13.0	7.2	5.8	6.8
Үхэр	20.8	24.0	21.6	17.0	16.8	17.4
Хонь	38.4	40.9	35.7	33.1	33.7	33.6
Ямаа	31.3	33.2	27.4	19.2	17.0	16.9

**Сүргийн бүтэц.** Нийт сүргийн 35.2 хувь нь төл, өсвөр насны, 40.4 хувь нь хээлтэгч, 23.2 хувь нь ажлын болон нас гүйцсэн эр мал, 1.2 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүргийн бүтэц ( хувиар )

	Төл, өсвөр насны		Ажлын ба эр сувай		Хээлтэгч		Хээлтүүлэгч		Бүгд
	1994	1995	1994	1995	1994	1995	1994	1995	
<b>ДҮН</b>	<b>34.6</b>	<b>35.2</b>	<b>21.3</b>	<b>23.2</b>	<b>42.9</b>	<b>40.4</b>	<b>1.2</b>	<b>1.2</b>	<b>100.0</b>
Тэмээ	29.1	29.2	42.1	41.9	27.5	27.6	1.3	1.3	100.0
Адуу	33.6	35.5	35.5	34.0	27.0	26.7	3.9	3.8	100.0
Үхэр	45.4	50.9	13.8	11.8	38.9	35.5	1.9	1.8	100.0
Хонь	34.4	34.6	19.1	21.3	45.8	43.4	0.7	0.7	100.0
Ямаа	31.0	30.2	23.1	26.7	45.2	42.3	0.8	0.8	100.0

Бойжуулсан төлийн тоо нэмэгдсэнээр ямаанаас бусад төрлийн малын сүргийн бүтцэд төл, өсвөр насны малын эзлэх хувийн жин өсөв. Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин 40.4 болж, урьд оныхоос 2.5 пунктээр буурсны дотор үнээ 3.5, эм ямаа 2.9, эм хонь 2.4, гүүний хувийн жин 0.3 пунктээр багасав.  
( Хавсралт хуудасны дугаар 12 – 17 )

Сүргийн бүтэц, өмчийн хэлбэрээр ( хувиар )

	хувийн			өмчийн бусад хэвшлийн		
	1993	1994	1995	1993	1994	1995
Төл, өсвөр насны	34.3	35.3	35.8	25.0	26.5	27.6
Ажлын ба эр сувай	21.4	21.3	23.3	22.0	21.6	22.9
Хээлтэгч	43.2	42.3	39.7	51.2	50.5	48.3
Хээлтүүлэгч	1.1	1.1	1.2	1.8	1.4	1.2
<b>БҮГД</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

1995 оны эцэст ажлын ба эр сувай 6642.8 мянган эр мал тоологдсон нь өмнөх оныхоос 922.2 мянгаар нэмэгдсэний дотор эр ямаа 605.6 мянга, эр хонь 293.9, адуу 45.2 мянга, тэмээ 0.1 мянгаар өсч, үхэр 22.5 мянгаар буурлаа.

## II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

**Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 1995 оны эцэст цэвэр үүлдрийн 756.1 мянга, эрлийз 900.4 мянга, нутгийн шилдэг омгийн 614.0 мянган мал тоологдов.

Нутгийн шилдэг омгийн малын тоо 1994 оныхоос буурч, цэвэр, эрлийз үүлдрийн мал 1.5 – 2.2 дахин өссөн нь нутгийн шилдэг омгийн малд тоологдож байсан Дорнод монгол үхэр, Жаргалант, Говь-Алтай, Баяд, Үзэмчин хонийг Хүнс, Хөдөө аж ахуйн яамны баталснаар цэвэр үүлдрийнхэд оруулан тоолж, зарим сум, баг, хороодод тухайн цэвэр, эрлийз үүлдрийн малыг нийт малаас суглаж бүртгэлгүй орхигдуулдаг дутагдалыг өнгөрсөн жил нилээд цэгцлэж, малыг үүлдэрээр ангилан тодорхойлж бүртгэн явуулсантай холбоотой. ( Хавсралт хуудасны дугаар 30, 31 )

1995 онд тоологдсон нийт үхрийн 4.9 хувь, хонины 8.9 хувь, ямааны 3.1 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 18.9 нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газарт, 78.4 хувь нь хувийн аж ахуйд байна.

1995 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 801.3 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын сүрэгт үнээ 42.6 хувь эм хонь 49.0 хувь, эм ямаа 49.1 хувийг эзлэж байна.

Нутгийн шилдэг омгийн үхэр ( хогорогийн монгол ) 3.1, хонь 536.7, ямаа 65.2 мянга тоологдлоо.

### Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн малын өсөлт, төрлөөр ( мян.тол )

	1993	1994	1995	1995\1994	
				хувь	зөрүү
<b>1.Цэвэр үүлдрийн бүх мал</b>	<b>334.8</b>	<b>338.6</b>	<b>756.1</b>	<b>223.3</b>	<b>417.5</b>
үхэр	46.2	39.3	51.4	130.8	12.1
хонь	221.8	226.6	626.8	276.6	400.2
ямаа	66.8	72.7	77.9	107.2	5.2
<b>2. Эрлийз</b>	<b>666.6</b>	<b>583.0</b>	<b>900.4</b>	<b>154.4</b>	<b>317.4</b>
үхэр	100.3	94.4	112.8	119.5	18.4
хонь	424.9	348.9	600.5	172.1	251.6
ямаа	141.4	139.7	187.1	133.9	47.4
<b>3.Нутгийн шилдэг омгийн</b>	<b>824.7</b>	<b>846.1</b>	<b>616.4</b>	<b>72.6</b>	<b>-232.1</b>
үхэр	17.5	25.5	3.1	12.2	-22.4
хонь	768.0	770.0	536.7	69.7	-233.3
ямаа	39.2	50.6	65.2	128.9	14.6
тэмээ			2.0		2.0
адуу			7.0		7.0

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. ( мян.тол )

	Нийт эрлийз мал		Үхэр		Хонь		Ямаа	
	1994	1995	1994	1995	1994	1995	1994	1995
ХАА-н компани,УУГ	320.6	312.8	43.3	64.5	257.5	241.8	19.8	6.5
Хувийн аж ахуй	545.6	1298.3	86.7	95.8	285.9	948.6	173.0	253.9
Бусад	55.3	45.4	3.7	3.9	32.1	36.9	19.5	4.6
ДҮН	921.5	1656.5	133.7	164.2	575.5	1227.3	212.3	265.0
Салбаруудын эзлэх хувийн жин								
ХАА-н компани,УУГ	34.8	18.9	32.4	39.3	44.7	19.7	9.3	2.5
Хувийн аж ахуй	59.2	78.4	64.8	58.3	49.7	77.3	81.5	95.8
Бусад	6.0	2.7	2.8	2.4	5.6	3.0	9.2	1.7
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

	Үхэр		Хонь		Ямаа	
	1994	1995	1994	1995	1994	1995
Бүгд	4.4	4.9	4.2	8.9	2.9	3.1
-Цэвэр	1.3	1.5	1.6	4.5	1.0	0.9
-Эрлийз	3.1	3.4	2.5	4.4	1.9	2.2
Үүнээс:ХАА-н компани	36.3	65.5	30.6	34.2	16.1	6.6
-Цэвэр	24.0	32.0	18.3	23.0	0.9	
-Эрлийз	12.4	33.5	12.3	11.2	15.2	6.6
Хувийн аж ахуй	3.0	3.1	2.4	7.8	2.5	3.1
-Цэвэр	0.3	0.6	0.6	3.8	0.7	0.9
-Эрлийз	2.7	2.5	1.8	4.0	1.8	2.2

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо ( мян.тол )

	1993	1994	1995	1995\1994	
				Хувь	Зөрүү
1.Цэвэр үүлдрийн хээлтэгч	180.9	178.4	375.4	210.4	197.0
Үнээ	22.1	20.7	22.3	107.7	1.6
Эм хонь	122.4	118.8	312.9	263.4	194.1
Эм ямаа	36.4	38.9	40.2	103.3	1.3
2.Эрлийз үүлдрийн	333.8	297.6	425.9	143.1	128.3
Үнээ	39.6	45.1	47.7	105.8	2.6
Эм хонь	225.1	179.8	288.2	160.3	108.4
Эм ямаа	69.1	72.7	90.0	123.8	17.3

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

	Үнээ	Эм хонь	Эм ямаа
--	------	---------	---------



	1994	1995	1994	1995	1994	1995
Бүгд	49.2	42.6	51.9	49.0	52.5	49.1
-Цэвэр	52.8	43.4	52.5	49.9	53.5	51.7
-Эрлийз	47.8	42.3	51.5	48.0	52.0	48.1
Үүнээс:ХАА-н компани	54.0	44.7	55.8	55.0	47.7	56.7
-Цэвэр	55.9	46.4	56.4	57.4	48.6	
-Эрлийз	50.5	43.0	54.9	50.3	47.7	56.7
Хувийн аж ахуй	47.0	41.1	48.5	47.4	51.7	48.1
-Цэвэр	44.2	37.9	43.9	47.3	49.4	48.8
-Эрлийз	47.4	41.9	50.0	47.4	52.6	47.8

### III. Малын хашаа, уст цэг

**III. Малын хашаа, худаг.** 1995 онд улсын хэмжээгээр 27.0 сая толгой малын багтаамжтай 93.2 мянган хашаа тоологдсон нь ноднин жилийнхээс хашааны тоо 9.1 мянгаар өсч, багтаамж нь 0.1 сая толгойгоор буурчээ.

Богийн 25.0 сая толгой малын багтаамжтай 74.6 мянган хашаа байгаагийн 11.1 хувь нь дулаан байр, дулаалгатай хашаа, 68.9 хувь нь саравчтай хашаа, 20.0 хувь нь саравчгүй хашаа байна. Эдгээр хашааны 89.4 хувь нь хувийн, 10.6 хувь нь аж ахуйн бусад хэвшлийнх байна.

1995 онд 2376.2 мянган толгой малын багтаамжтай 9718 хашаа шинээр ашиглалтанд оруулсан нь ноднин жилийнхээс 1870 хашаагаар нэмэгджээ.

Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн малын хашааны багтаамж ноднин жилийнхээс 4.5-1268.9 мянган малынхаар буурсан байна.

#### Малын хашааны тоо, багтаамж, хувиар

	1986-1990 оны дундаж	1992	1993	1994	1995	1995\1994 хувь
Хашаа бүгд(мян)	67.8	74.4	76.1	84.1	93.2	110.9
Багтаамж (сая.тол)	31.4	27.7	26.1	27.1	27.0	99.4
Шинээр барьсан хашааны тоо	2015	4993	6188	7848	9718	123.8
Багтаамж (сая.тол)	0.9	1.0	1.9	1.2	2.4	200.0
Хашаажилтын хувь –бод	105.6	65.4	65.6	61.8	60.2	94.5
--бог	154.7	127.8	120.6	118.8	111.2	99.6

1995 оны байдлаар бог мал 1.1 ээлжийн хашаагаар, үхрийн 60.2 хувь нь нэг ээлжийн хашаагаар хангагдсан байна.

Говьсүмбэр, Завхан, Дундговь, Увс, Өвөрхангай, Төв аймагт бог малын хашааны хангамж бусад аймгаас харьцангуй доогуур байна. ( Хавсралт хуудасны дугаар 35 – 37 )

**Уст цэг.** Улсын хэмжээгээр 1986-1990 онд дунджаар 41.9 мянган худагтай байсан бол 1995 оны эцэст 34.6 мянган худаг тоологджээ. 1995 онд шинээр 1138 худаг ашиглалтанд оруулсны 1117 нь энгийн уурхайн худаг байна.

1994 оныхоос энгийн уурхайн худаг 1973-аар нэмэгдэж, инженерийн байгууламжтай худаг 2947-оор буурчээ.

Нийт худгийн тоо 11 аймагт 1994 оныхоос буурсны дотор Төв, Дундговь, Дорнод аймагт 124 – 686, Увс, Завхан, Говь-Алтай, Булган, Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймагт 12 – 93 худгаар багасчээ. ( Хавсралт 38 )

Уст цэгийн тоо ( мян.ш )

	1986-1990 дундаж	1992	1993	1994	1995	1995\1994 хувь
Худаг бүгд	41.9	36.3	36.3	35.6	34.6	97.3
Үүнээс:Инженерийн байгууламжтай	25.0	20.7	19.2	17.5	14.6	83.2
Энгийн уурхайн	16.9	15.6	17.1	18.1	20.0	110.9
Мал услах сан	4.2	2.9	2.6	2.2	1.9	88.4

Улсын хэмжээгээр 1995 онд 27.7 мянган м.куб багтаамжтай 1934 мал услах сан тоологдсон нь ноднин жилийнхээс 255-аар буурсан байна. 26.4 мянган га талбай услах хүчин чадалтай 88 услалтын систем байгаагаас 1994 оныхоос услалтын систем 12-оор, хүчин чадал нь 4.7 мянган га-аар буурчээ. ( Хавсралт хуудасны дугаар 39 )

1995 онд эвдрэлтэй, ашиглагдаггүй худаг 6200 байгаа нь ноднин жилийнхээс 18.4 хувиар их байна.

Ашиглалтгүй худгийг аймгаар үзүүлбэл:

Ашиглалтгүй байгаа худгийн тоо	А Й М А Г
5 – 195	Баян-Өлгий, Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Говьсүмбэр, Орхон
215 – 237	Сүхбаатар, Ховд, Завхан, Булган
323 – 594	Дундговь, Дорноговь, Төв, Дорнод, Хөвсгөл, Хэнтий, Говь-Алтай, Өмнөговь, Баянхонгор, Архангай, Өвөрхангай

### III.2. Малын тэжээлийн үйлдвэрлэлт

**Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж.** 1995 онд улсын хэмжээгээр 437.3 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1994 оныхоос 17.2 хувь буюу 64.0 мянган тонноор нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл бэлтгэсэн өвс, сүрэл, нэг наст өвс, гар ба эрдэс тэжээлийн хэмжээ өмнөх оныхоос нэмэгдэж, харин олон наст өвс, багсармал тэжээл, бэлтгэсэн даршны хэмжээ багассан байна.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ ( тэжээлийн нэгжид шилжүүлсэнээр ) Дундговь аймагт хадлан 46.8 хувь, Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Төв, Ховд аймагт 0.8-0.9 хувиар тус тус буурсан байна.

1995 онд улсын хэмжээгээр 781.5 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 89.7 мянган тонноор буюу 13.0 хувь нэмэгдэв. Харин дээр дурьдсан Өвөрхангайгаас бусад аймаг болон Сүхбаатар аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ 1994 оныхоос буурсан байна. ( Хавсралт 40 – 43 )

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : ( мян.т )

	1991	1992	1993	1994	1995	1995\1994 хувь
Байгалийн хадлан	878.6	668.8	689.7	691.8	781.5	113.0
Сүрэл	54.6	31.9	26.7	22.3	100.6	451.7
Нэг наст өвс	65.9	25.0	18.0	4.0	6.3	156.1
Олон наст өвс	8.2	8.3	4.7	1.4	0.7	51.8
Гар тэжээл (тэж.нэгж)	10.1	6.6	7.6	11.6	15.0	129.8
Бэлтгэсэн тэжээл	23.6	21.0	15.1	13.8	13.8	99.7
Бэлтгэсэн дарш	91.1	128.7	64.4	30.5	19.2	62.7
Эрдэс тэжээл	15.5	12.9	16.8	18.9	26.3	139.4
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	564.4	403.7	410.9	373.3	437.3	117.2

Сүүлийн жилүүдэд нийт тэжээлд хүчит болон шүүст тэжээлийн эзлэх хувийн жин буурч байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж  
( хувиар )

	1991	1992	1993	1994	1995
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
хүчит	15.2	11.5	15.3	9.5	7.4
шүүст	5.3	7.1	3.9	2.2	1.8
бүдүүн	77.6	81.4	80.8	88.3	87.4
Бусад	1.9	-	-	-	3.4

1995 оны байдлаар хонин толгойд шилжүүлснээр нэг малд тэжээлийн нэгжээр 7.1 кг тэжээл ногдож байгаа нь 1994 оныхоос 0.6 кг-аар нэмэгдсэн бөгөөд энэ нь нийт малыг 3.6 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

#### IV. Тэжээвэр амьтад.

1995 оны эцэст 23.5 мянган гахай, 99.3 мянган шувуу, туулай 118, үнэг 568, булга 180 тоологдов. Урьд оныхоос гахайн тоо 0.1 мянга, шувууны тоо 25.2 мянгаар өсч, 1991 оныхоос гахайн тоо 3.5 дахин, шувууны тоо 2.2 дахин цөөрлөө.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрхийн тоо

	1991	1992	1993	1994	1995	1995\1994
Гахай (мян.тол)	83.3	48.6	28.6	23.4	23.5	100.4
Шувуу (мян.тол)	223.3	184.0	131.6	74.1	99.3	134.1
Цаа буга	1336	1427	1415	1170	900	76.9
Илжиг	791	935	874	993	913	91.9
Зөгий бүл	4567	1473	1237	1386	1165	84.1
Туулай	2047	164	142	129	118	91.5
Үнэг	1209	1001	1060	215	568	264.2
Булга	7513	6005	4571	2696	180	6.7
Гахайтай өрхийн тоо (мян)	12.1	7.6	5.4	4.1	4.2	101.2
Шувуутай өрхийн тоо	1336	1569	1813	1792	2218	123.8
Гахай өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	482	225	148	97	111	114.4
Шувуу өсгөж үржүүлдэг АА, байгууллагын тоо	56	37	33	22	25	113.6

Улаанбаатар хотын үслэг ангийн аж ахуй 1995 онд булгагүй болжээ.

Нийт гахайн тоо 1994 оныхоос Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Орхон, Увс, Хэнтий, Говьсүмбэр, Баянхонгор зэрэг 8 аймаг, Улаанбаатар хотод нийтдээ 2269 толгойгоор өсч, бусад 13 аймагт 2179 толгойгоор хорогдов. Шувууны тоо Дархан-Уул, Булган, Хэнтий, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорноговь зэрэг 7 аймаг, Улаанбаатар хотод нийтдээ 26.7 мян.толгойгоор өсч, бусад 14 аймагт 1.5 мян.толгойгоор буурсан байна. ( Хавсралт хуудасны дугаар 32-34 )

1994 онд аминдаа гахайтай өрх 4.2 мянга, шувуутай өрх 2.2 мянга болсон нь 1994 оныхоос гахайтай өрх 51-ээр, шувуутай өрх 426-аар нэмэгдэв. Гахайтай өрхийн тоо Сэлэнгэ, Орхон аймаг, Улаанбаатар хотод, шувуутай өрхийн тоо Сэлэнгэ, Төв, Булган, Орхон аймаг, Улаанбаатар хотод өссөн байна.

Одоо нийт гахайны 80.4 хувь, шувууны 20.1 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр ( мян.тол )

	Гахай				Үндсэн мэгж			Хувийн жин
	1994	1995	1995\1994 хувь	Хувийн жин	1994	1995	1995\1994 хувь	
Дүн	23.4	23.5	100.4	100.0	5542	6376	115.0	100.0
Үүнээс: хувийн аж ахуй	20.0	18.9	94.3	80.4	4881	5183	106.2	81.3

үргэлжлэл

	Шувуу				Өндөглөгч			Хувийн жин
	1994	1995	1994\1994 хувь	Хувийн жин	1994	1995	1995\1994 хувь	
Дүн	74.1	99.3	134.1	100.0	33.8	33.7	99.6	100.0
Үүнээс: хувийн аж ахуй	22.5	19.9	88.7	20.1	15.0	12.3	82.0	36.6

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....